

Сурган хүмүүжүүлэгч та бүхэнд

お子さんを持つ保護者の皆様へ

Сургуульд суралцах талаар гадаадын иргэнд зориулсан тайлбар
Японы сургуульд бүртгүүлэн орох тухай

外国人のための就学ガイド
～日本の学校への入学手続きについて～



モンゴル語 モンゴル хэл

Япон улсын бага, дунд сургуулийн тухай

Гадаадын иргэн улсын бага, дунд сургуульд суралцахыг хүсвэл үнэ төлбөргүйгээр, япон иргэний нэгэн адил боловсрол эзэмших боломжтой.

日本の小学校・中学校について

外国人の子どもも、公立の小学校・中学校への入学を希望する場合は、日本人児童生徒と同様に無償で受け入れており、日本人と同一の教育を受ける機会を保障しています。

■ Бага, дунд сургуулийн сургалтын хугацааны тухай

Японд 6 нас хүрсэн хүүхдийг 4 сараас эхлэн бага сургуульд бүртгэн оруулж, 6 жилийн ерөнхий боловсрол эзэмшүүлнэ. Бага сургууль төгссөний дараа дунд сургуульд дэвшин суралцуулж, 3 жилийн ерөнхий боловсрол эзэмшүүлнэ.

■ 小学校・中学校の就学期間について

日本では、小学校は満6歳を過ぎた最初の4月から入学することができ、6年間の教育を受けます。小学校を卒業すると中学校に入学することができ、3年間の教育を受けます。

■ Сургалтын төлбөр, сурах бичгийн тухай

Улсын бага, дунд сургуульд үнэ төлбөргүйгээр боловсрол олгоно. Мөн бага, дунд сургуулийн сурах бичгийг үнэ төлбөргүйгээр тараан олгоно. Харин сургуулийн өдрийн хоол, ангийн сургалтын материалын төлбөрийг сар бүр төлнө.

■ 授業料、教科書について

公立の小学校・中学校の授業料は無償です。また、小学校・中学校の教科書は、無償で配布されます。なお、給食費・学年費等は、毎月支払うこととなります。

■ Сургалтын тэтгэмжийн тухай

Эдийн засгийн шалтгаас болж бага, дунд сургуульд сурах бэрхшээлтэй бол хот, дүүргийн боловсролын зөвлөлийн зөвшөөрлөөр, сургуулийн сургалтын материал ба өдрийн хоолны төлбөрт тэтгэмж үзүүлнэ.

■ 就学援助について

経済的理由により、小学校・中学校への就学が難しいと、市町村の教育委員会から認められた場合、学用品の購入費や給食費への援助を受けることができます。

■ Хамрагдах хичээл

Бага сургуульд япон хэл, нийгэм судлал, тоо бодох, байгалийн ухаан, амьдрахуйн ухаан, дуу хөгжим, зураг, хөдөлмөр ба биеийн тамирын хичээл, ёс суртахууны хичээл, дугуйлан ба хичээлээс гадуурх сургалт зэрэг хичээлүүд орно.

Дунд сургуульд япон хэл, нийгэм судлал, математик, байгалийн ухаан, дуу хөгжим, дүрслэх урлаг, биеийн тамир, техник хөдөлмөр, гэр ахуйн хичээл ба гадаад хэл (үндсэндээ англи хэл) болон ёс суртахууны хичээл, дугуйлан ба хичээлээс гадуурх сургалт зэрэг хичээлүүд орно.

■ 学校で学ぶ教科

小学校では、国語、社会、算数、理科、生活、音楽、図画工作、家庭及び体育の各教科、道徳、特別活動及び総合的な学習の時間について学びます。

中学校では、国語、社会、数学、理科、音楽、美術、保健体育、技術・家庭及び外国語(原則として英語)などの各教科、道徳、特別活動及び総合的な学習の時間について学びます。



* РТА-гийн үйл ажиллагаа

Сургуульд «РТА» гэдэг эцэг эхчүүд, сурагчдын зөвлөл байдаг ба «сургуулиас аюул осолгүй харих байдлыг хамгаалан удирдах» зэрэг үйл ажиллагааг хамтран явуулна. Сурган хүмүүжүүлэгчдийн идэвхитэй оролцоо шаардлагатай.

* PTA活動

学校には「PTA」という保護者と先生の会があり、保護者と先生が協力し合って「登下校時の安全指導」などの活動を行っています。保護者の積極的な参加が望まれます。

Улсын бага, дунд сургуульд бүртгүүлэх дараалал

公立の小学校・中学校への入学手続の流れ

1

Сурган хүмүүжүүлэгч эхлээд оршин суугаа хот, дүүргийн гадаад иргэний бүртгэлийн газар болон боловсролын зөвлөлд хандан хүүхдээ бага, дунд сургуульд суралцуулах хүсэлтэй байгаагаа мэдэгдэнэ үү.
«Хүүхдээ сургуульд оруулмаар байгаа тул бичиг баримт бүрдүүлж өгөхийг хүсье.»

保護者は、初めに居住する市区町村の外国人登録窓口や教育委員会に行って、子どもの小学校、中学校への入学の希望を伝えてください。「子どもを学校に入学させたいので、手続きをお願いします。」

2

Сургуулиа тодорхойлж, сургуульд орох бичиг баримтыг бүрдүүлнэ.
(Үндсэн журмын дагуу суралцах хүүхдийн настай дүйцэх ангид оруулна.)

入学する学校を決めて、手続きをします。
(原則として、子どもの年齢相当の学年に編入されます。)

3

Сурган хүмүүжүүлэгч хүүхдийнхээ хамт сургууль дээр очно уу. Анги даасан багштай уулзан, цаашдийн сургалтын талаар харилцан ярилцана уу.
«Боловсролын зөвлөлд бичиг баримт бүрдүүлэн өгч, цаашид энэ сургуульд суралцах болсон тул сургуульд орох бүртгэлтийг хийж өгнө үү.»

保護者は、子どもと一緒に入学する学校へ行ってください。そこで、先生と今後の学校生活について話し合ってください。「教育委員会で手続きをして、こちらの学校に入学することになったので、入学手続きをお願いします。」

Дунд сургууль төгссөнөөр ирээдүйн олон зам нээгдэнэ!

中学校を卒業するといろいろな未来が広がります！

● Дунд сургууль төгссөний дараах сонголт

Японд дунд сургууль төгссөн олонхи сурагчид ахлах сургуульд дэвшин суралцдаг. Мэргэжлийн коллеж болон тусгай мэргэжлийн сургууль, ердийн ерөнхий боловсролын сургуульд дэвшин суралцах ба ажилд орох хүүхэд ч байдаг.

● 中学校卒業後の進路

日本では、中学校を卒業した生徒の多くは高等学校に進学します。また、高等専門学校や専修学校一般・高等課程に進学する人や、就職する人もいます。